



МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ, ҮЙЛ ЯВЦЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН АРГА ЗҮЙ ЗААВАР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (976) 77073689
Цахим хуудас: www.mnas.gov.mn
Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:	ӨӨРЧЛӨЛТ NO: 01
24.06.2016	ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 31.07.2024

АГУУЛГА

Sl.	Бүлэг	Хуудас
	Агуулга	2
1	Зорилго	3
2	Хамрах хүрээ	3
3.	Нэр томъёо ба тодорхойлолт	3
4.	Үүрэг хариуцлага	4
5.	Хүсэлт гаргагчид тавих шаардлага	4
6.	Итгэмжлэлийн үйл явц	5
	6.1 Итгэмжлэлийн хүсэлт ба үнэлгээний төлөвлөлт	5
	6.2 Үнэлгээний арга зүй	5
	6.3 Үнэлгээний үр дүнг тайлагнах	9
	6.4 Итгэмжлэлийг хадгалах	9
	6.5 Гэрчлэх үнэлгээний нэмэлт зохицуулалт	11
7.	Холбогдох баримт бичиг	11
	ХАВСРАЛТ А: Тохирлын үнэлгээний схемийн элементүүд	13

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 2/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

1 **ЗОРИЛГО**

Энэхүү арга зүйн зааврын зорилго нь Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын анхдагч итгэмжлэл, магадлах хяналт, давтан итгэмжлэл болон хүрээ өргөтгөх үнэлгээний үед MNAS-ийн үнэлгээний мэргэжилтэн гэрчлэх үнэлгээг сонгох шалгуур, итгэмжлэлийн үйл явцыг тодорхойлно. Мөн итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагатай холбоотой гомдлын дагуу болон магадлах хяналтын хүрээнд хэрэгжих төлөвлөгөөт бус гэрчлэх үнэлгээний нөхцөл, журмыг тайлбарласан болно.

Итгэмжлэлийн үйл ажиллагааг MNAS P701 Итгэмжлэлийн үйл явцын журам, энэхүү арга зүйн заавруудтай уялдуулан хамтад нь хэрэглэнэ.

2 **ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү арга зүйн заавар нь MNAS-аас хэрэгжүүлэх Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ)-ын итгэмжлэлийн үнэлгээний үйл ажиллагаанд үнэлгээний мэргэжилтнүүдийн баримтлах аргачлал, шаардлагыг тодорхойлно. Үүнд анхдагч итгэмжлэл, давтан итгэмжлэл, хүрээ өргөтгөх үнэлгээ, магадлах хяналт болон гомдлын дагуух үнэлгээ хамаарна.

Энэ баримт бичгийг ISO/IEC 17065 стандарт болон олон улсын баримт бичгүүдэд үндэслэсэн бөгөөд үндсэндээ үнэлгээний мэргэжилтнүүдэд зориулсан болно. Гэсэн хэдий ч энэхүү баримт бичиг нь баталгаажуулалтын байгууллагад мөн хамааралтай тул итгэмжлэлийн шалгуур, үйл явцын талаарх нийтлэг ойлголтыг авах хүрээнд танилцах боломжтой.

3 **НЭР ТОМЪЁО БА ТОДОРХОЙЛОЛТ**

- 3.1 **Итгэмжлэл** - тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхитайг нь албан ёсоор харуулсан хөндлөнгийн этгээдийн баталгаа.
- 3.2 **Баталгаажуулалтын байгууллага (ББ)** - Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцыг үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа явуулдаг, итгэмжлэлд хамрагдаж болох байгууллага.
- 3.3 **Бүтээгдэхүүн, үйлчилгээний, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ)** - ISO/IEC 17065 стандартад нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын үйл ажиллагаа эрхэлдэг баталгаажуулалтын байгууллага
- 3.4 **Магадлах хяналт** - Итгэмжлэл олгосны дараа итгэмжлэлийн шаардлагын хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор MNAS-аас гүйцэтгэдэг төлөвлөгөөт үнэлгээ.
- 3.5 **Гэрчлэх үнэлгээ** - Итгэмжлэлийн үнэлгээний хүрээнд үнэлгээний мэргэжилтнүүд баталгаажуулалтын байгууллагын гүйцэтгэж буй тохирлын үнэлгээний үйл явц, үнэлгээний багийн ажиллах чадавх болон хамааралтай үйл явцын хэрэгжилтийг ажиглаж, үнэлэх үйл ажиллагаа.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 3/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

3.6 Хамрах хүрээ өргөтгөх - Баталгаажуулалтын байгууллага итгэмжлэлийн хүчинтэй хугацаанд шинэ салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын хамрах хүрээ эсвэл нэмэлт баталгаажуулалтын үйл ажиллагааг хамруулах хүсэлт гаргасан тохиолдолд хийгддэг үнэлгээ.

3.7 Гомдлын мөрөөр хийх үнэлгээ - Итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдлын дагуу MNAS-аас хэрэгжүүлдэг газар дээрх болон/эсвэл оффисын үнэлгээ.

3.8 Анхдагч итгэмжлэл - Баталгаажуулалтын байгууллагыг анх удаа MNAS-аас итгэмжлэх зорилгоор хийгддэг иж бүрэн үнэлгээ.

3.9 Давтан итгэмжлэл - Итгэмжлэлийн хугацаа дуусахаас өмнө MNAS болон олон улсын шаардлагуудыг үргэлжлүүлэн хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор хэрэгжүүлдэг дахин итгэмжлэлийн үйл явц.

4 ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

MNAS нь итгэмжлэлийн үнэлгээг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцна. Энэхүү үйл ажиллагааг холбогдох стандарт болон хараат бус байдал, чадамж, нэгдмэл байдлыг хангах зарчимд нийцсэн байхаар хэрэгжүүлнэ.

(Итгэмжлэлийн) Үнэлгээний баг нь багийн ахлагч, үнэлгээчид болон техникийн шинжээчдээс бүрдэх ба мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйн хэм хэмжээг чандлан баримтлан үнэлгээ гүйцэтгэх үүрэгтэй. Баг нь тухайн үнэлж буй хамрах хүрээнд холбогдох чадамжийг нотлон харуулахын зэрэгцээ нууцлал, хараат бус байдлыг хадгалах үүрэгтэй.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ) нь итгэмжлэлийн үнэлгээний үйл явцын үеэр бүрэн хамтран ажиллах үүрэгтэй. Үүнд, итгэмжлэлийн хамрах хүрээнд хамаарах холбогдох бичиг баримт, ажилтан, үйлчлүүлэгчийн байршилд цаг тухайд нь хандах боломж олгох, мөн MNAS-ын бүх шаардлага, журам болон хугацааг чанд мөрдөх зэрэг багтана.

5 ХҮСЭЛТ ГАРГАГЧИД ТАВИХ ШААРДЛАГА

MNAS-аар итгэмжлүүлэхийн тулд Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ) нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- ~ Хууль ёсны хуулийн этгээдээр бий болсон/бүртгэгдсэн байх;
- ~ ISO/IEC 17065 стандартад нийцсэн, баримтжуулсан менежментийн тогтолцоотой байх;
- ~ Баталгаажуулалтын үйл ажиллагаатай нь холбоотой техникийн чадамж, үйл ажиллагааны чадавхи, байгууллагын хараат бус байдлыг нотолж харуулах;
- ~ MNAS-аас тогтоосон загвар, шаардлагын дагуу бүрэн бүрдүүлсэн итгэмжлэлийн хүсэлт болон хавсралт баримт бичгүүдийг ирүүлэх;
- ~ MNAS-ын бүх холбогдох итгэмжлэлийн журам, үнэлгээ болон магадлах хяналтын шаардлагыг хүлээн зөвшөөрч мөрдөх, мөн итгэмжлэлийн үйл явцын хүрээнд тавигдах нөхцөл шаардлагуудыг биелүүлэх үүрэг хүлээх.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 4/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

6 ИТГЭМЖЛЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

6.1 Итгэмжлэлийн хүсэлт ба үнэлгээний төлөвлөлт

6.1.1 MNAS нь бүрэн гүйцэд бүрдүүлсэн итгэмжлэлийн хүсэлтийг хүлээн авсны дараа тухайн Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ) нь хүсэлт гаргагчийн шаардлагыг хангаж буй эсэхийг урьдчилан нягтална. Үүнд тухайн байгууллагын хуулийн этгээдийн нотолгоо болон бүртгэл, баталгаажуулалтын үйл ажиллагааны хамрах хүрээ, байгууллагын бүтэц зохион байгуулалт, чанарын гарын авлага, журам, хараат бус байдлын зохицуулалт, аудитын бүртгэл, ажилтнуудын чадамжийн мэдээлэл зэрэг менежментийн тогтолцооны баримт бичгийн бүрдэл, хангалттай байдал зэргийг баталгаажуулах хяналт багтах ба хэрэв ямар нэгэн дутуу зүйл илэрвэл MNAS нь үнэлгээний дараагийн шат руу шилжихээс өмнө тодруулга эсвэл нэмэлт баримт бичиг шаардана.

6.1.2 MNAS нь БББ-ын итгэмжлэгдэхээр хүсэлт гаргаж буй хамрах хүрээ болон холбогдох салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын итгэмжлэлийн үнэлгээний туршлагатай үнэлгээний багийг томилох бөгөөд баг нь нийтдээ тухайн хамрах хүрээтэй холбоотой чиглэлд техникийн чадамжтай байна.

6.1.3 Үнэлгээний багийн ахлагч нь

- i. БББ-аас итгэмжлүүлэхээр хүсэлт гаргасан бүтээгдэхүүн/бүтээгдэхүүний бүлэг, итгэмжлэлийн хүрээний тодорхойлолт, баталгаажуулалтын схемийг нягтална.
- ii. Хүсэлт гаргасан хамрах хүрээг итгэмжлэх боломжтой эсэхийг үнэлнэ. Энэхүү үнэлгээнд дараах алхмуудыг гүйцэтгэнэ
 - a. Хүсэлт гаргасан хүрээ нь бүтээгдэхүүний баталгаажуулалтын ажиллагаа мөн эсэх;
 - b. Холбогдох бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллага нь хүсэлт гаргасан итгэмжлэлийн хүрээндээ ямар нэг үйл ажиллагаа (олгосон итгэмжлэлийн гэрчилгээний дараа холбогдох яамдуудаас зөвшөөрөл авах замаар ажиллагааг эхлүүлэх гэх мэт онцгой нөхцөлүүдийг үл хамруулан) явуулсан эсэх;
 - c. Хүсэлт гаргасан итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод заасан баталгаажуулалт хийх хангалттай (өргөдөл хүлээн авахаас шийдвэр гаргах түвшинд техникийн болон хүний нөөцийг хамруулан) нөөцтэй эсэх.

6.2 Үнэлгээний арга зүй

MNAS нь Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ)-ын ISO/IEC 17065 стандарт болон холбогдох салбарын стандартад нийцэж буй байдал, чадамжийг үнэлэх зорилгоор төрөл бүрийн үнэлгээний аргыг хэрэгжүүлэх ба уг аргачлал нь баримт бичгийн хяналт, оффисын үнэлгээ, баталгаажуулалтын аудитын гэрчлэх үнэлгээ болон аудитын баримт бичгийн үнэлгээ зэргээс бүрдэнэ.

6.2.1 Баримт бичгийн дүн шинжилгээ

Газар дээрх үнэлгээ хийхээс өмнө MNAS нь БББ-ын баримтжуулсан менежментийн тогтолцоонд дүн шинжилгээ хийнэ. Үүнд, шударга байдлын бодлого, журам, аудиторын чадамж, аудит төлөвлөлт ба хэрэгжилт, шийдвэр гаргах үйл явц, гомдол хүлээн авах,

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 5/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

шийдвэрлэх, дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой бодлого, журам багтана. Мөн баримт бичгийн дүн шинжилгээгээр БББ-ын үйл ажиллагаа нь ISO/IEC 17065 стандарт болон холбогдох итгэмжлэлийн шалгуур баримт бичгүүдийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг урьдчилсан байдлаар баталгаажуулна.

6.2.2 Оффис үнэлгээ

Энэ үнэлгээг БББ-ын төв оффис эсвэл холбогдох үйл ажиллагааны байршилд гүйцэтгэнэ. Энэ нь баримтжуулсан журмын хэрэгжилтийг баталгаажуулах, баталгаажуулалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй тогтолцооны тохиромжтой байдлыг үнэлэхэд чиглэнэ. Үүнд баталгаажуулалтын шинжээчийн чадамж, мониторинг, тохирлын үнэлгээний хөтөлбөрийн төлөвлөлт, дотоод аудит, удирдлагын дүн шинжилгээ болон баталгаажуулалтын шийдвэртэй холбоотой баримт бичгүүдийг үнэлэх үйл ажиллагаа зэрэг багтана.

6.2.3 Гэрчлэх үнэлгээ

Итгэмжлэлийн гэрчлэх үнэлгээ нь итгэмжлэлийн үнэлгээний чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ нь техникийн хүрээний гол үйл явцыг шалгах, баталгаажуулалтын шинжээчдийн ур чадварыг харуулах зорилгоор сонгох үнэлгээ бөгөөд итгэмжлэлийн хамрах хүрээг төлөөлөх хэмжээнд байна. Ихэнхдээ гэрчлэх үнэлгээ нь 1 эсхүл 2 хүн, 2 өдөр байна. Энэ нь ISO/IEC 17065 болон бусад хөтөлбөрийн нэмэлт шаардлага стандартуудад тодорхойлсон өргөн хүрээний аудитын үйл явцыг харуулахад оршино.

MNAS нь БББ-аас хэрэгжүүлж буй сонгосон баталгаажуулалтын үнэлгээнд ажиглалт хийж, баталгаажуулалтын шинжээчийн чадамж болон тохирлын үнэлгээний газар дээрх үйл явцын үр нөлөөг баталгаажуулна. Үнэлгээний баг нь чухал салбар, бүтээгдэхүүн, үйл явцын хүрээнд анхдагч эсхүл давтан баталгаажуулалтын аудитыг гэрчлэхээр тэргүүн ээлжинд сонгох үүрэгтэй.

Гэрчлэх үнэлгээнд хамрагдах баталгаажуулалтыг сонгохдоо ОУИФ-ын заавал мөрдөх баримт бичгийн шаардлага, эрсдэлд суурилсан зарчим, чухал салбар, бүтээгдэхүүн, техникийн бүлэглэл, болон тохирлын үнэлгээний үе шат (жишээлбэл: анхдагч, магадлах хяналт, давтан баталгаажуулалт)-ыг харгалзан үзнэ.

Гэрчлэх баталгаажуулалтын тоо, төрлийг шийдэхдээ MNAS дараахь хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

- i) ББ-ын нийт гүйцэтгэл;
- ii) Баталгаажсан байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын хүлээгдэж буй үр дүнд хүрэх чадварт нөлөөлөх нарийн төвөгтэй байдал, хууль тогтоомж зэрэг хүчин зүйлс;
- iii) ББ-ын итгэмжлэлийн хамрах хүрээн дэх үйлчлүүлэгчдийн тоо;
- iv) Олон төрлийн баталгаажуулалтын схем ба бүтээгдэхүүний ангилал, схем эзэмшигчийн шаардлага;
- v) Баталгаажсан байгууллагын байгууллагын талаарх гомдол, зарга буюу сонирхогч талуудын ирүүлсэн мэдээлэл;
- vi) ББ-ын дотоод аудитын үр дүн;
- vii) ББ-ын ажлын өөрчлөлт-тодорхой бус байдал, техникийн салбар дахь ажлын өсөлт;
- viii) ББ-ын баталгаажуулалтын шинжээчдийн үнэлгээ, хүлээн зөвшөөрөх үйл явцын найдвартай байдал; болон
- ix) өмнө хийгдсэн эсвэл бусад оффис эсвэл гэрчлэх үнэлгээний үр дүн гэх мэт багтана.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 6/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

Харгалзах нэмэлт хүчин зүйлс:

- a) олгосон гэрчилгээний тоо;
- b) баталгаажуулалтын шинжээчдийн тоо, чадамж;
- c) баталгаажуулалтын шинжээчид нь дотоод эсвэл гадаад эх үүсвэрээс эсэх;
- d) баталгаажуулалтын үйл явцад аудит гүйцэтгэх улс орнууд;
- e) сүүлд хийгдсэн гэрчлэх үнэлгээний үр дүн;
- f) гомдол, хэрэглэгчийн судалгаа;
- g) сонирхогч талууд ба захиргааны байгууллагын шаардлага;
- h) өмнө нь үнэлсэн техникийн бүлгүүд;
- i) ББ-ын итгэмжлэлийн бусад төрлүүдээс хуримтлуулсан туршлага;
- j) ББ өөрийн үйл ажиллагааг өмнө нь удирдаж байсан чадвартай эсэх;
- k) ББ өөрийн чухал үйл ажиллагааг хянах хяналтын түвшин;
- l) тодорхой схемийн шаардлага;
- m) үйлчлүүлэгчтэй хийсэн үндэсний хэлэлцээр.

Баталгаажуулалтын байгууллага, хэрэв боломжтой бол MNAS үнэлгээний баг болон баталгаажуулалтын байгууллагын үнэлгээний баг нь гэрчлэх үнэлгээний нээлтийн хурлын өмнө богино хэмжээний уулзалтыг хийх боломжийг хангасан байна. Энэ уулзалтын зорилго нь гэрчлэх үнэлгээний мөн чанар, хамрах хүрээ, хүлээлтийг тодорхойлж, аудитын явцад оролцогчдын үүрэг, мэргэжлийн ёс зүйн талаар нийтлэг ойлголттой байдлыг хангахад оршино.

Гэрчлэх үнэлгээ нь ихэвчлэн нээлтийн хурлаас хаалтын хурал хүртэлх тохирлын үнэлгээний бүх үйл явцыг хамарна. Гэвч үнэлгээний зорилгод хүрэх боломжтой бол хэсэгчилсэн байдлаар гэрчлэх үнэлгээ хийхийг зөвшөөрнө. MNAS-ын үнэлгээний баг тохирлын үнэлгээний явцад хөндлөнгөөс оролцох, БББ болон түүний үйлчлүүлэгчид санал, зөвлөмж өгөх, үзэл бодлоо илэрхийлэх эсвэл үйлчлүүлэгчээс шууд асуулт асуух, ярилцлага хийхийг хориглоно. Харилцаа зөвхөн завсарлага эсвэл үнэлгээний багийн дотоод хурлын үеэр явагдана.

Гэрчлэх үнэлгээний дараа MNAS нь баталгаажуулалтын байгууллагын үнэлгээний багт ажиглалтын үр дүнгийн талаар танилцуулна. Үүнийг баталгаажуулалтын байгууллагын удирдлагад мөн танилцуулж болох ба баталгаажуулалтын байгууллагын үйлчлүүлэгч оролцохыг хориглоно.

Баталгаажуулалтын байгууллагын тохирлын үнэлгээний тайлан болон үнэлгээний үеэр хянан үзсэн холбогдох баримт бичигт MNAS-ын үнэлгээний мэргэжилтний хүсэлтийн дагуу танилцах боломжийг БББ олгоно. Ингэхдээ эдгээр бүх мэдээллийг MNAS-ын бодлогын дагуу нууцын зэрэглэлтэйгээр авч үзнэ.

Гэрчлэх үнэлгээний явцад ноцтой үл тохирол илэрсэн тохиолдолд MNAS нь ижил төстэй баталгаажуулалтын үнэлгээнд дахин гэрчлэх үнэлгээ зохион байгуулахыг БББ-аас шаардаж болно. Энэхүү арга хэмжээ нь залруулах үйл ажиллагааны үр нөлөөг баталгаажуулах зорилготой. Давтагдсан үл тохирол, эсвэл шийдвэрлэгдээгүй дутагдал илэрсэн нөхцөлд MNAS нь итгэмжлэлийн үйл явцын журмын дагуу тухайн БББ-ын итгэмжлэлийн хамрах хүрээг багасгах, түдгэлзүүлэх хүртэлх арга хэмжээ авна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 7/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

6.2.3.1 Төлөвлөгөөт гэрчлэх үнэлгээ

МТББ нь итгэмжлэлийн үнэлгээний өмнө буюу хамгийн багадаа 15 хоногийн өмнө төлөвлөж буй тохирлын үнэлгээ, магадлах аудитын хуваариа MNAS-д ирүүлнэ. Энэхүү хуваарьт үйлчлүүлэгчийн мэдээлэл, газар дээрх үнэлгээний огноо, баталгаажуулалтын хамрах хүрээ, баталгаажуулалтын схем, техникийн шаардлага буюу норматив баримт бичгийн мэдээлэл тусгагдсан байна.

Мөн гэрчлэх үйл ажиллагаанаас өмнө, хамгийн багадаа нэг долоо хоногийн өмнө MNAS-ын үнэлгээний багт дараах баримт бичгийг хүргүүлэх шаардлагатай. Үүнд:

- Менежментийн тогтолцооны гарын авлага болон журам (хэрэв байгаа бол);
- Өмнөх тохирлын үнэлгээ, магадлах үнэлгээний тайлангууд (хэрэв байгаа бол);
- Баталгаажуулалтын схемийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- Газар дээрх үнэлгээний багийн бүрэлдэхүүний мэдээлэл;
- MNAS-аас шаардсан бусад холбогдох баримт бичиг.

6.2.3.2 Төлөвлөгөөт бус гэрчлэх үнэлгээ

MNAS нь магадлан хяналт хийх явцад эсвэл эрсдэл, гомдол, мөн тодорхой чиглэлд үйл ажиллагаа дутагдсан гэж үзсэн тохиолдолд төлөвлөгөөгүй гэрчлэх үнэлгээг эхлүүлж болно. Энэ үнэлгээ нь MNAS-д шаардлагад үргэлжлүүлэн нийцэж байгааг шалгах, холбогдох асуудлуудыг шийдвэрлэх боломжийг олгоно.

Төлөвлөөт бус гэрчлэх үнэлгээ хийх нөхцлүүдэд дараахь зүйлс багтах байх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- Баталгаажуулсан үйлчлүүлэгчидтэй холбогдсон ноцтой гомдлууд;
- Гурван жилээс дээш хугацаанд тодорхой чиглэлд баталгаажуулалтын үйл ажиллагаа байхгүй байх;
- БББ-ны байгууллага, үйл явцад орсон томоохон өөрчлөлтүүд;
- MNAS-аас эрсдэлтэй гэж авч үзсэн санамсаргүй сонголт.

6.2.4 Аудитын баримт бичгийн хяналт

MNAS нь БББ-ын гүйцэтгэсэн тохирлын гэрчилгээнд хамаарах баримт бичгүүдээс түүвэрлэн тус хяналтыг явуулна. Энэ үйл ажиллагаа нь баталгаажуулалтын байгууллагын тохирлын үнэлгээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал болон баталгаажуулалтын шийдвэр гаргалт нь хэрхэн шаардлагад нийцэж байгааг нотлох, тогтолцоо нь бүрдэж хэвшсэн байдлыг үнэлэх зорилготой. Тохирлын гэрчилгээнд хамаарах баримт бичгийн хяналт нь тохирлын үнэлгээний тайлан, шалгах хуудсууд, үл тохирол, санал, бусад холбогдох ажиглалт бүхий дүгнэлт, баталгаажуулалтын шийдвэрийн баримт бичгүүдийг хамарна. Ингэхдээ баталгаажуулалтын шинжээчийн ур чадварын нотолгоо болон тохирлын үнэлгээний бүхий л үйл явц дахь шударга байдлын механизмд онцгой анхаарал хандуулвал зохино.

6.2.5 Эрсдэлд суурилсан түүвэрлэх зарчим

Үнэлгээний баг нь эрсдэлд суурилсан түүвэрлэх зарчмыг баримтална. Аудит болон баримт бичгийг үнэлэх арга хэрэгслүүдийг сонгохдоо БББ-ын үйлчлүүлэгчдийн хүрээ, итгэмжлэлийн хамрах хүрээ, гэрээт болон гадаад баталгаажуулалтын шинжээчдийг ашигласан байдал, хамрагдаж буй салбарын нарийн төвөгтэй байдал зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзнэ. Алсын зайн баталгаажуулалт, импортын тохирлын гэрчилгээнд хамаарах

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 8/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

үнэлгээ болон олон салбартай байгууллагын баталгаажуулалтыг холбогдох баримт бичгийн шаардлагын дагуу үнэлнэ.

6.3 Үнэлгээний үр дүнг тайлагнах

6.3.1 Үнэлгээний баг нь үнэлгээний явцад ажиглагдсан бүх холбогдох ажиглалтыг, үүнд үл тохирол, сайжруулах арга хэмжээний хүрээнд өгч буй зөвлөмж, давуу тал (шаардлагатай тохиолдолд) баримтжуулах үүрэгтэй.

6.3.2 Үнэлгээний багийн ахлагч нь үнэлгээний үйл ажиллагаа, итгэмжлэлийн шаардлага, шалгуурт нийцэж буй байдал, үнэлгээний явцад илэрсэн бүх ажиглалтыг нэгтгэн дүгнэсэн дэлгэрэнгүй үнэлгээний тайланг бэлтгэнэ.

6.3.3 Баталгаажуулалтын байгууллага нь MNAS-аас тогтоосон хугацааны дотор үнэлгээний багийн ахлагчид дараах зүйлсийг багтаасан хэрэгжүүлсэн ажлын тайланг ирүүлнэ. Үүнд:

- **(а) Үл тохирлын хувьд:**
 - Учир шалтгааны шинжилгээ хийсэн болон залруулах арга хэмжээ авсан баримт;
 - Залруулах арга хэмжээний үр дүнтэй байдлын нотолгоо, хэрэв бүрэн хэрэгжилт хараахан хийгдээгүй бол — хэрэгжилтийн эцсийн хугацааг тусгасан төлөвлөгөө
- **(б) Ажил сайжруулах зөвлөмжийн хувьд:**
 - Хариу өгөхийг зөвлөмжилж буй бөгөөд заавал байх шаардлагагүй.

***Тайлбар:** Баталгаажуулалтын байгууллагын хэрэгжүүлсэн ажлын тайланг үнэлгээний тайлан дахь тухайн илэрсэн үл тохирол бүрийн доор бичиж, шаардлагатай бол авсан залруулах арга хэмжээний нотлох баримтыг хавсаргана.*

6.3.4 Багийн ахлагч нь ирүүлсэн залруулах арга хэмжээний хангалттай байдал, үр нөлөөг хянан, үнэлж, итгэмжлэлийн шийдвэр гаргахтай холбоотой санал, дүгнэлтийг боловсруулан MNAS-д ирүүлнэ.

6.4 Итгэмжлэлийг хадгалах

6.4.1 Итгэмжлэлийн статусыг хадгалахын тулд Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ) нь ISO/IEC 17065 стандарт, холбогдох салбарын нэмэлт стандартууд, мөн MNAS-ын журам болон итгэмжлэлийн нөхцөл шаардлагуудыг байнга, тогтмол мөрдөх үүрэгтэй.

6.4.2 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын үндсэн үүрэгт дараах зүйлс хамаарна. Үүнд:

- Итгэмжлэлийн шалгуур шаардлагад нийцэж буйг үнэлэх магадлах хяналт болон давтан үнэлгээнд амжилттай хамрагдах;
- Үнэлгээний үр дүнд өгөгдсөн ажлын үр дүн, шаардлагыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх;

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 9/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

- Баталгаажуулалтын үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй байгууллагын бүтцийн өөрчлөлт, хуулийн статус, голлох ажилтан зэрэг чухал мэдээллийг MNAS-д тухай бүр гэрээнд дурдсанаар мэдээлэх;
- MNAS-тай хамтран ажиллах, шаардлагатай бичиг баримт, ажилтан, талбайд нэвтрэх боломж олгох;
- Итгэмжлэлтэй холбоотой төлбөр, хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;
- MNAS-аас гаргасан бүх заавар, шаардлагыг биелүүлэх.

Дээрх үүрэг, шаардлагыг хангаагүй тохиолдолд итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хамрах хүрээг багасгах, эсвэл хүчингүй болгох шийдвэр гаргаж болно.

6.4.3 Баталгаажуулалтын байгууллага нь өөрийн аудитууд, баталгаажуулсан бүтээгдэхүүн, үйлчлүүлэгчийн нэр, баталгаажуулалтын хамрах хүрээ зэрэг багтсан итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын хүрээнд олгосон тохирлын гэрчилгээний жагсаалт, мэдээллийг жил бүрийн 12-р сарын байдлаар MNAS-д ирүүлнэ. Тогтоосон хугацаанд дээр дурдсан мэдээллүүдийг ирүүлээгүй тохиолдолд MNAS-аас түдгэлзүүлэх, итгэмжлэлийн хамрах хүрээг өргөтгөхгүй байх, итгэмжлэлийг буцаах эсвэл давтан итгэмжлэхгүй байх зэрэг арга хэмжээг авч болно.

6.4.4 MNAS нь баталгаажуулалтын байгууллага итгэмжлэлийн шалгуурт үргэлжлүүлэн нийцэж буйг баталгаажуулах зорилгоор жил бүр магадлах хяналт, дөрвөн (анхдагч итгэмжлэлийн хувьд хоёр) жил тутам давтан үнэлгээ хийдэг. Эдгээр үнэлгээ нь ББ-ын хамрах хүрээ, эрсдэлийн түвшин, үйлчлүүлэгчийн цар хүрээг харгалзан оффисын үнэлгээ, бичиг баримтын шалгалт, гэрчлэх үнэлгээг багтаана. Гэрчлэх үнэлгээг итгэмжлэлийн мөчлөгийн туршид хуваарилан гүйцэтгэх бөгөөд өндөр эрсдэлтэй салбарт онцгой анхаарал хандуулна.

6.4.5 Магадлах хяналтын гэрчлэх үнэлгээнд анхдагч итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдаагүй бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний дэд бүлгийг түүвэрлэх ба итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын хамрах хүрээ тус бүрээс дор хаяж нэг гэрчлэх үнэлгээ заавал хийгдсэн байх шаардлагатай.

6.4.6 Итгэмжлэлийн мөчлөгийн туршид MNAS-ийн үнэлгээний баг нь аль болох баталгаажуулалтын байгууллагын нөөцөд байгаа бүх баталгаажуулалтын шинжээч, техникийн шинжээчдийн ажлыг гэрчлэх үнэлгээнд хамруулсан байх шаардлагатай. Иймд баталгаажуулалтын байгууллага нь гэрчлэх үнэлгээ бүрт өөр өөр багийн гишүүдийг томилно.

6.4.7 Баталгаажуулалтын байгууллагын менежментийн тогтолцоо, бие даасан, хараат бус, шударга байдлын үнэлгээнээс гадна ажилтнуудын чадамж, техникийн ур чадвар, итгэмжлэгдсэн хамрах хүрээн дэх үйл ажиллагааны тогтвортой байдал нь итгэмжлэлийн үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн нэг мөн. БББ нь итгэмжлэлийн мөчлөгийн хугацаанд тодорхой салбар, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцад гэрчлэх үнэлгээ хийх боломжгүй, тохирлын үнэлгээний үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн чиглэлээр ур чадвар, чадавх хадгалагдаж байгаа эсэхийг бодитойгоор нотлох боломж хязгаарлагдмалд тооцогдоно. Иймд итгэмжлэлийн үнэлгээний баг нь үйл ажиллагаа явуулаагүй хамрах хүрээг үнэлгээний тайланд тусгаж, тухайн хамрах хүрээг итгэмжлэлийн хүрээнээс хасах саналыг дэвшүүлнэ.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 10/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

6.4.8 Итгэмжлэлийн хүрээ өргөтгөх үед MNAS нь заавал нэг удаа тухайн хамрах хүрээнд гэрчлэх үнэлгээ хийх шаардлагатай. Хэрэв баталгаажуулалтын үйл ажиллагаа байхгүй бол MNAS нь хамрах хүрээ өргөтгөх үнэлгээг хойшлуулна.

6.4.9 БББ нь олгосон гэрчилгээний мэдээллийг MNS ISO/IEC 17065 стандартын 7.8-д заасны дагуу Баталгаажуулсан бүтээгдэхүүн (үйлчилгээ, үйл явцын)-ий лавлах хэсгийг өөрийн мэдээллийн сандаа байршуулна. Хэрэв мэдээлэлд алдаа, зөрүү эсвэл дутуу зүйл илэрсэн тохиолдолд тухайн мэдээллийг илрүүлсэн даруйд, уртдаа хоёр долоо хоногийн дотор засварлаж, гүйцэт, зөв мэдээллийг байршуулах үүрэгтэй.

6.5 Гэрчлэх үнэлгээний нэмэлт зохицуулалт

6.5.1 Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллага (БББ) нь өөрийн үйлчлүүлэгчдээ MNAS-ын үнэлгээний мэргэжилтэн аудитын явцад оролцох тухай урьдчилан мэдэгдэж, гэрчлэх үнэлгээг тайлбарлан, үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг авах үүрэгтэй. Зөвхөн гэрчлэх үнэлгээний улмаас ББ нь тохирлын үнэлгээний баг, төлөвлөгөө, үнэлгээний хугацаанд өөрчлөлт оруулах шаардлагагүй. Хэрэв ямар нэгэн өөрчлөлт хийх тохиолдолд ББ нь уг өөрчлөлтийн үндэслэл, тайлбарыг MNAS-д албан ёсоор мэдэгдэнэ.

6.5.2 ББ-ийн үйлчлүүлэгч нь газар дээрх үнэлгээ эхлэхээс өмнө БББ-ийн тохирлын үнэлгээний баг болон MNAS-ын үнэлгээний мэргэжилтнүүдэд байгууллагын аюулгүй ажиллагаа болон нэвтрэх журамтай холбоотой шаардлагыг бүрэн танилцуулах үүрэгтэй. MNAS-ын үнэлгээний мэргэжилтэн нь тухайн байгууллагаас тогтоосон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг чанд мөрдөнө. Гэсэн хэдий ч, үнэлгээний мэргэжилтэн нь гэмтэл, эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай тохиолдолд өөрийн оролцоог зогсоох, тухайн газрыг орхих зэрэг арга хэмжээг өөрсдийн зүгээс авах эрхтэй.

6.5.3 Газар дээрх гэрчлэх үнэлгээний явцад MNAS-ын үнэлгээний мэргэжилтний зүгээс эрүүл мэнд, аюулгүй байдал эсхүл байгаль орчинд ноцтой хохирол учруулах шууд аюултай нөхцөл байдлыг илрүүлсэн тохиолдолд энэхүү асуудлыг БББ-ийн багийн ахлагчид хувийн уулзалт зохион байгуулж яаралтай мэдэгдэнэ. Энэхүү асуудлыг БББ нь өөрийн дотоод журам болон холбогдох хууль, эрх зүйн шаардлагын дагуу зохих арга хэмжээг авч шийдвэрлэх үүрэгтэй.

6.5.4 MNAS-ын үнэлгээний мэргэжилтэн нь тохирлын үнэлгээний бүх үе шатыг хамруулан гэрчлэх үнэлгээ хийгээгүй тохиолдолд үнэлгээний тайланд гэрчлэх үед ажигласан үйл ажиллагаа, үе шат, төлөвлөгөөний холбогдох хэсэг, үнэлгээ хийсэн менежментийн тогтолцооны шаардлагыг тусгайлан тэмдэглэнэ.

6.5.5 Хэрэв БББ нь үндсэн бүртгэлээс гадаад байршилд үйлчлүүлэгчдийг баталгаажуулсан бол тухайн үйлчлүүлэгчийн мэдээллийг MNAS-д мэдэгдэнэ. MNAS нь тухайн үйлчлүүлэгчийн аудитыг гэрчлэх үнэлгээний төлөвлөгөөнд оруулах эсэхийг шийднэ.

7 ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

- **MNAS P402** Нууцыг хадгалах журам

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 11/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

- **MNAS P602** Итгэмжлэлийн үйл ажиллагаанд оролцох ажилтныг үнэлэх, гүйцэтгэлд мониторинг хийж журам
- **MNAS P701** Итгэмжлэлийн үйл явцын журам
- **MNAS P702** Итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох буюу хүрээг багасгах, өргөтгөх журам

---XXX---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
	Өөрчлөлт No: 01	
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	Page: 12/16
Хэвлэсэн огноо: 24.06.2016		

ХАВСРАЛТ А: Тохирлын үнэлгээний схемийн элементүүд

1. Баталгаажуулалтын схем нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:
 - а) Бие даасан байгууллагууд эзэмшдэг олон улсад танигдсан тохирлын үнэлгээний схемүүд. Жишээ нь, Global Gap Scheme, FSSC 22000 Scheme
 - б) Засгийн газрын эрх зүйн баримт бичигт тусгагдсан үндэсний хэмжээнд хэрэгждэг тохирлын үнэлгээний схемүүд. Жишээ нь, Европын Холбооны CE тэмдэглэгээний схем, FSSAI-ийн Органик зохицуулалт
 - в) Сайн дурын үндсэн дээр төрийн эсхүл зохицуулагч байгууллагаас боловсруулан, удирддаг тохирлын үнэлгээний схемүүд
 - г) Төрийн бус бусад (салбарын холбоо, худалдааны сүлжээ гэх мэт) байгууллагаас боловсруулсан тохирлын үнэлгээний схемүүд.
 - д) Тохирлын үнэлгээний байгууллагууд өөрсдөө боловсруулж, хэрэгжүүлдэг тохирлын үнэлгээний схемүүд, жишээ нь Agmark
2. БББ нь баталгаажуулалтын схемийн дагуу баримт бичгийг бүрдүүлнэ. Энэхүү баталгаажуулалтын схемд баталгаажуулалт хийх аргыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгасан байна. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагууд ISO/IEC 17067-д тодорхойлсон баталгаажуулалтын схемийн төрлүүдийг хэрэглэх боломжтой. Мөн техникийн баримт бичиг ISO/IEC TR 17026-д дээж бүтээгдэхүүний баталгаажуулалтын схем (төрөл 5), ISO/IEC TR 17028-д үйлчилгээний баталгаажуулалтын схемийн талаарх зааврыг өгдөг.
3. Баталгаажуулалтын схемийг тухайн асуудлаар хангалттай мэдлэг, туршлагатай, тухайн салбартаа ур чадвартай гэдгээ нотолсон ур чадвартай хүмүүс IAF MLA Level 3-ын стандарт баримт бичгийн хүрээнд боловсруулна. Энэхүү ур чадвар гэдэгт техник ойлголтоос гадна тохирлын үнэлгээний талаарх мэдлэг хамаарна. Баталгаажуулалтын схем хүчинтэй байх эсэхийг үйлдвэрлэгч, харилцагч, хэрэглэгч болон бусад сонирхогч талуудын тэгш төлөөллийг оролцуулж, тэдгээрийн санал ба оролцоог авч үзсэн байна.
4. Схемийн тодорхой агуулгыг боловсруулахын тулд оролцогч талуудын хооронд схемийн үндсэн зарчмыг зөвшилцсөн байна. Үүнд:
 - ~ өмчлөлийн баталгаа,
 - ~ оролцогч талуудын шууд оролцоо байж болох эсэх талаар төрийн болон шийдвэр гаргах механизмын баталгаа,
 - ~ голлох бизнес болон санхүүжилтийн хэлбэрийн баталгаа,
 - ~ схемд мониторинг болон давтамжтай дүн шинжилгээ хийх үндэслэлийг гаргах.
5. Схем эзэмшигч нь хуулийн этгээд байх ба схемийн зорилго, агуулга, нэгдмэл байдлын бүрэн хариуцлагыг хүлээж, схемийн агуулгыг баримтжуулсан байна. Энэ нь ТҮБ-д үүнийг хоёрдмол утгагүй, тууштай хэрэгжүүлэх боломжийг хангахуйц хангалттай нарийвчилсан, ойлгомжтой байна.
6. Схем эзэмшигч нь схемийг сахин сайжруулах ба шаардлагыг тогтоох, өөрчлөх эрхтэй байх бөгөөд схемийг ямар нэгэн нэмэлт, хасалтгүйгээр ашиглах, мөн схем эзэмшигчийн дүрэм журмыг дагаж мөрдөхийг агуулсан зохицуулалтыг бий болгосон байна.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 13/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

7. Схем эзэмшигч нь схемийг зорилгодоо нийцэж буйг тодорхойлох, батлах зорилгоор оролцогч талуудыг хамруулан тогтмол дүн шинжилгээ хийж, схемтэй холбоотой гомдлыг авч үзэх, шийдвэрлэх үйл ажиллагаатай байна.

8. Схем эзэмшигч нь баталгаажуулалтын байгууллага ба түүний үйлчлүүлэгч схемийг эш татах, хамрах хүрээнд зах зээлийн сурталчилгаа хийх бодлого, зохицуулалтыг тодорхойлж, баталгаажуулалтыг хуурамчаар мэдүүлсэн нөхцөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг хариуцлагыг тодорхойлно.

9. БББ нь баталгаажуулалтын схемд үндэслэн баталгаажуулах бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцыг хянах бүхий үйл ажиллагааг багтаасан журамтай байх бөгөөд энэ нь тохирлын үнэлгээний үйл явцын үр дүнгийн нэгдмэл, уялдаатай байдлыг хангана.

Нэмэлт тайлбар: Баталгаажуулалтын байгууллагын үйлчлүүлэгчийн хувьд хүсэлт гаргаж буй хамрах хүрээндээ шаардлагатай стандартын эсвэл/ба зохицуулалтын баримт бичгүүдэд заасан бүх нөхцөлүүдийг биелүүлнэ. (Жишээ нь: Бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулахын тулд баталгаажуулалтын норматив баримт бичигт заасан бүх сорилтыг хийлгэсэн байх шаардлагатай)

10. Баталгаажуулалтын схем нь дараах 4 үндсэн үе шатаас бүрдэнэ. Үүнд:

i. Сонголт (дээж авах)
Энэ үйл явц нь үнэлгээ өгөхөд шаардлагатай боломжит нөхцөл байдлыг тодорхойлох, шаардлагыг үнэлж, сонгох, төлөвлөх, мэдээлэл цуглуулах, түүвэрлэх гэх мэт үйл ажиллагааг багтаана. Бүтээгдэхүүний баталгаажуулалтын схемийн хувьд дээжийг хэзээ, хаанаас, хэн авах зэрэг шаардлага нь энд багтана. Тухайн дээжүүд нь баталгаажуулалт гаргаж чадах хэмжээний бүтээгдэхүүний шугам эсвэл бүтээгдэхүүний бүлгийг бүхэлд нь төлөөлөх бөгөөд ижил аргаар, ижил бүтээгдэхүүний шугамаар эрэмбэлж, үйлдвэрлэж буй үйл ажиллагаанаас сонгоно.

ii. Тодорхойлолт
Энэ үйл явцад шинж чанарын үзүүлэлт, нэг буюу түүнээс дээш тодорхойлох аргачлал (сорилт, хяналт гэх мэт)-ыг ашиглах мэдээлэл зэрэг ажиллагааг багтаана. Тодорхойлсон нөхцөл байдлын биелэлтийг хянах олон аргуудын жишээ байдаг ба холбогдох стандартуудын дагуу сорилт, хэмжилт, хяналт шалгалт, зураг төсөл, үнэлгээ, дүгнэлт болон аудитын хяналт зэрийг ойлгоно. Шинж чанарын тодорхойлолт нь бодит хэмжсэн үнэлгээ болон шаардлагатай (тухайлбал, зөвшөөрөгдөх дээд хэмжээ) үнэлгээг харьцуулсан хэмжээ байна.
Баталгаажуулалтын байгууллага өөрсдийн дээж аваагүй сорилтын дүнг ашиглах бол сорилт, шинжилгээ, хяналт гүйцэтгэсэн холбогдох байгууллага нь ISO/IEC 17025, ISO/IEC 17020 стандартын дагуу итгэмжлэгдсэн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нь хянана.

iii. Дүн шинжилгээ
Энэ үйл явц нь чанар болон тоон шинжүүд нь заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтоох, бодит нотолгоог шалгах, дүгнэх үйл ажиллагааг багтаана. Тодорхойлолт (үнэлэлт өгөх)-ын үе шатны үр дүнг хэрхэн тайлагнах, эдгээрийг баталгаажуулалтын байгууллага болон схемийг эзэмшигч хэрхэн хэрэглэх тухай мэдээлэл байна.

iv. Шийдвэр ба аттестатчилал

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	Page: 14/16
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	

Энэ нь баталгаажуулалтын шийдвэр гаргах үйл ажиллагааны буюу баталгаажуулалтын хамрах хүрээг олгох, хадгалах, үргэлжлүүлэх, сунгах, хамрах хүрээг багасгах, баталгаажуулалтыг түдгэлзүүлэх ба хүчингүй болгох зэрэг нөхцлүүдийг багтаана. Баталгаажуулалтын байгууллага нь тохирлын гэрчилгээ болон тэмдгийг ашиглах эрх олгох шийдвэрийг албан ёсоор баримтжуулна. Тохирлын мэдэгдэл эсвэл тохирлын тэмдгийг ашиглах нөхцөлийг тодорхойлно. Ингэхдээ тохирлын тэмдгийг эзэмших, ашиглах, хянах зэргийг багтаасан хянах хүчин төгөлдөр гэрээтэй байна.

Гэхдээ шаардлагатай тохиолдолд дээр дурьдсан 4 үе шат дээр нэмж бүтээгдэхүүний баталгаажуулалтын магадлах хяналтын үе шат ордог. Энэ нь тогтоосон шаардлагад үргэлжлэн нийцэж байгааг шалгах, гэнэтийн сорилт буюу хяналт хийх үйл ажиллагааг ойлгоно. Баталгаажуулалтын схемд магадлах хяналтын үе шат багтсан бол магадлах хяналтын багц үйл ажиллагааг тодорхойлж, ингэхдээ схем эзэмшигч нь баталгаажуулалтад хамрагдах зүйлийн мөн чанар, үл тохирох бүтээгдэхүүний үр дагавар, боломж болон үйл ажиллагааны давтамжийг авч үзнэ.

11. Баталгаажуулалтын схемд хууль эрх зүйн шаардлагуудыг багтаасан бол эдгээр шаардлагыг дагаж мөрдөх тухай зааж, тохирлын үнэлгээний үр дүнгийн нөхцөл болохыг тусгана.

12. Схем эзэмшигч нь схемд ашиглаж буй тогтоосон шаардлагыг тодорхойлсон стандарт болон бусад норматив баримт бичгийн боловсруулалтанд мониторинг хийнэ. Хэрэв эдгээр баримт бичиг өөрчлөлт орвол схемд шаардлагатай өөрчлөлтийг оруулах болон баталгаажуулалтын байгууллага, үйлчлүүлэгч, шаардлагатай бол бусад харилцагчдаас өөрчлөлтийн хэрэгжүүлэлтийг удирдах (жишээ нь: шилжилтийн хугацаа) үйл явцтай байна.

---oOo---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
	Өөрчлөлт No: 01	
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	
Хэвлэсэн огноо: 24.06.2016		Page: 15/16

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

<u>Өөрчлөлт No.</u>	<u>Огноо</u>	<u>Баталсан</u>	<u>Хуудасны дугаар</u>	<u>Оруулсан өөрчлөлт</u>
01	31.07.2024	MNAS дарга	Бүх хуудас	~ Баримт бичгийн агуулгыг сайжруулсан. ~ ОУИФ-ын IAF MD 25 заавал мөрдөх баримт бичиг, MNAS P701 PC F03 Тохирлын үнэлгээний схемийг үнэлэх/шалгах хуудаст нийцүүлсэн.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ

Баримт бичгийн No: MNAS AG06	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцын баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн арга зүйн заавар	
Хэвлэсэн огноо: 24.06.2016	Өөрчлөлт No: 01	
	Өөрчлөлтийн огноо: 31.07.2024	
		Page: 16/16